

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батын Алтангэрэл	Дугаар	L060
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Халхгол сум
Төрсөн газар	Дорнод аймаг Халхгол сум	Төрсөн он	1932
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Халхын сүм	Сүм хийдийн дугаар	ДОХГ 039
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 11	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Халхгол сумын Халхын сүм

-Танай орон нутагт ямар ямар сүм хийд байсан бэ?

Оршуун голын тэнд Халхын сүм байсан. Энэ хошууны анхны хийд байсан газар. Наана нь лусын бумба булсан газарт нь овоо босгосон байгаа. Сүм хийд нь цаахна нь байсан юм байна лээ.

-Өөр танай нутагт ямар хийд байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Буйр нуурын баруунд эндхийн л нэг хийд байсан. Баргын нүүдэллэж явсан хийд болов уу. Булан дэрсний харуулын энтээ байгаа газар. Тамсагт То вангийн үед асар сүм боссон юм байна лээ. Утай таван уулыг байгуулсан. Олон сүмүүдийг татаж авч нэгтгэсэн. Тамсагт Түмэн-Өлзийтийн овоо гэж дээрээ том сүмтэй том хийд байсан гэж байгаа. То вангийн өргөө дэргэд нь байсан. Харш марш байгуулж байсан.

-Түмэн-Өлзийтийн энгэр дээр насны 3 бурхан байгуулсан юм уу?

Тэрийг мэдэхгүй. То вангийн үед бий болсон юм гэсэн.

-Тамсагт хэдэн хийд байсан бэ?

Тамсагийн сүмийг То вангийн үед томсгосон юм гэнэ лээ. Бас ямар юмны хоолой гэлээ тэнд нэг хийд байсан гэсэн. Тамсагт хоёр хийд байсан. Нэг нь их том хийд Тамсаг булгийн хойд дээр Утай уулын дэргэд. Тамсагийн хийд. Нэг нь Түмэн-Өлзийтийн хийд гэж энэ зүүн хойхно ойрхон байгаа. Давхар сүмтэй. То вангийн өөрийнх нь шүтээн байсан. Ордон босгож байсан гэсэн. Хоорондоо нэлээд зайтай. Бас бие биенээ харахаар тийм газар даа. Тэгээд наашаа Буйрын баруун талд талд нэг хийд байгаа юм. Тэр одоо аль хийд юм. Хилийн доторхон талд л байгаа байх гэж санаж байна. Энд чинь булан дэрсний харуул байсан. 39 онд эзлэгдсэн харуул л даа. Одоо Улаан худаг болчихоод байгаа. Тэрнээс арай наахна Уушхай гэж ярьдаг. Тэрний хойхно биеэр 3 зам гарсан байдаг. Тэр зам чинь л тэр хийд очдог байсан зам. Тэгээд Халхын сүм. Тэгээд Их бурхантын баруун урд дээр хийд байсан.

-Утай таван уулын хийдийн тухай?

Уулан дороо сүм нь байсан гэдэг. Хүн хэлсэн доор нь орж үзсэн. Том зурган бурхантай том хийд байсан гэж хэлж байсан. 70-аад оны үед томоо гуулин бурханы гар гараад ирчихсэн байж л байсан. Явж байгаад үзсэн.

Сүүлдээ тэнд ферм энэ тэр байгуулсан.

-Баян-Өлзийтийн хийд гэж дуулсан уу?

Түмэн-Өлзийтийн хийд биш үү?

Хулстын хийд гэж? Мэдэхгүй байна.

-Эрхэмсэг бэйсийн хүрээ гэж ?

Энэ Матадын нутагт байдаг хийд байх аа.